



**ОТАГ**  
ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ОРХОН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын код: ОРА-  
2018/1/СТА-ТЕЗ**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

Орхон аймгийн Тэргүүлэх аудитор  
Ц.Нармандах  
Утас: 70353088  
orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ  
Утас: 70355805  
Цахим хаяг:

Аудитор: Г.Оргилмөрөн  
Утас: 70350757  
Цахим хаяг:

**ТАБ-ын хаяг:** Орхон аймаг дахь  
Төрийн аудитын газар  
**Байршил:** Хүрэнбулаг баг  
Нутгийн удирдлагын ордон  
**Цахим хуудас:** [www.audit.mn](http://www.audit.mn)

## Аудитын тайлан

1. Аудитын гэрчилгээ
2. Аудитын тайлан
3. Менежментийн захидал
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлийн тайлан

## Агуулга

<b>1</b>	<b>Аудитын гэрчилгээ</b>	<b>2</b>
<b>2</b>	<b>Аудитын тайлан</b>	<b>4</b>
2.1	Товчилсон үгийн жагсаалт	4
2.2	Аудитын талаарх үндсэн мэдээлэл	5
2.3	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН БОДЛОГО, АРГАЧЛАЛ	5
2.4	САНХҮҮГИЙН ДОТООД ХЯНАЛТ	6
2.5	Шилэн дансны хуулийн хэрэгжилт	7
2.6	САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР	7
2.7	САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
	Нэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8
	Хоёр. Авлага	10
	Гурав. Урьдчилгаа	11
	Дөрөв. Бараа материал	11
	Тав. Нөөцийн бараа	12
	Зургаа. Үндсэн хөрөнгө	12
	Долоо. Өр төлбөр	14
	Найм. Засгийн газрын хувь оролцоо	16
	Ес. Орлогын талаар	16
	Арав. Зардлын талаар	17
	Арван нэг. Нэмэлт санхүүжилтийн тайлан	21
	Арван хоёр. Орон нутгийн өмчит ААН-ийн бүртгэл	22
2.8	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮН	23
2.9	ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ	27
2.10	САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ	27
<b>3</b>	<b>Менежментийн захидал</b>	<b>29</b>
3.1	Орлогын талаар	31
3.2	Мөнгөн хөрөнгийн талаар	31
3.3	Зардлын талаар	32
3.4	Авлага, өр төлбөрийн талаар	33
<b>4</b>	<b>Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл</b>	<b>34</b>
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	34
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	36
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	39
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	43
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан	43

## 1 Аудитын гэрчилгээ



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Д.БАТЛУТ ТАНАА

### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61000 Эрдэнэт хот, Амарын талбай,  
УБД 2070001050, Нутгийн удирдлагын ордон  
Утас/Факс: 70359826  
E-mail: orkhon@audit.gov.mn

2018.04.20 № 31

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Зөрчилгүй санал дүгнэлт

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2 Аудитын тайлан

### 2.1 Товчилсон үгийн жагсаалт

АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ААН	Аж ахуй нэгж
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
СХС	Сум хөгжүүлэх сан
ТАХОСС	Төрийн албан хаагчийн орон сууцны сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
БГАУТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БХӨТ	Богино хугацаат өр төлбөр
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ШУТП	Шинжлэх ухаан технологийн парк
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УОО	Урьдчилж орсон орлого
ДТС	Дулаан түгээх сүлжээ
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТББ	Төрийн бус байгууллага
БСУГ	Боловсрол, соёл, урлагын газар
ЗД	Засаг дарга
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ХББЗА	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ХАХНХС	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
БСШУС	Боловсрол соёл, шинжлэх ухааны сайд
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ОАТ	Орлогын албан татвар

## **2.2 Аудитын ТАЛААРХ ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ**

### **Аудит хийсэн үндэслэл, хугацаа**

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд хүрээнд энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

### **Аудитын зорилт, хамарсан хүрээ**

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг тэдгээр тайланд хавсаргах ёстой. Эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт бөгөөд хамарсан асуудлууд болно.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газар аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргахын өмнө Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу орон нутгийн бүх шатны төсвийн захирагчид, төсөл сан, ОНӨААН-үүдийн 2017 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан болно.

### **Аудитын арга зүй**

Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болгон, СТАУС програм хангамж ашиглан хяналтын сорил, шинжилгээний горим гүйцэтгэж санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

### **Материаллаг байдлын түвшин**

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд ТШЗ-дын санхүүгийн тайлан, төсөл сан болон орон нутгийн өмчит ААН-үүдийн санхүүгийн тайлангууд нэгтгэгддэг тул материаллаг байдлын түвшинг Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс 2.0 хувиар тооцож 3,839.3 сая төгрөгөөр тогтоосон болно.

## **2.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН БОДЛОГО, АРГАЧЛАЛ**

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь заалтын дагуу ТЕЗ-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэн гаргаж, хуульд заасан хугацаанд Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланд бүх төсвийн шууд захирагчид, төрийн сан, төсөл, сангууд, төрийн болон орон нутгийн өмчийн ААН, байгууллагуудын нэгтгэлийн дүнг тус тусад нь баганаар харуулжээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллага хооронд үүссэн давхардсан ажил гүйлгээ, орлого зардлыг цэвэрлэж тайлагнасан байна.

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд:

- Төсөвт байгууллагын 84 санхүүгийн тайлан - /Эрдэнэт сан, Авто замын сан, ОНХС-3, ОНХО-1, СХС-2, Халамжийн сан, Ор.Засаг дарга данс, Улсын төсвийн орлого төвлөрүүлэх данс багтсан./
- Төрийн сангийн 2 санхүүгийн тайлан,
- Төсөл сангийн 1 санхүүгийн тайлан - /ТАХОССан-татан буугдсан /
- Орон нутгийн өмчит 6 ААН-ийн санхүүгийн тайлангуудыг тус тус нэгтгэсэн байна.

### Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС-д шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал суурийг хэрэглэж бэлтгэсэн байна.

### Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж

Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дах заалтын дагуу Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж, санхүүгийн нэгтгэсэн тайлан болон тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна.

### Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-т заасны дагуу дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд :

А.Үндсэн тайлан	Б.Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В.Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	НББ-ийн бодлого зарчим Тайлангийн тодруулгууд
Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	
Орхон аймгийн ТЕЗ-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	
Орхон аймгийн ТЕЗ-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх тайлангуудыг Сангийн сайдын 2016 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн “Э-тайлан” програмаар нэгтгэн гаргажээ.

## 2.4 САНХҮҮГИЙН ДОТООД ХЯНАЛТ

Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасны дагуу Орхон аймгийн ТЕЗ-ын Санхүүгийн хяналт, аудитын алба нь 9 орон тоотойгоор, Сангийн яамнаас стандарт, арга зүйн удирдлагаар хангаж, Засгийн газрын 2015 оны 483-р тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус алба 2017 онд төлөвлөгөөт 68 хяналт шалгалт гүйцэтгэхээс 60 хяналт шалгалт гүйцэтгэсэн байна. Энэ нь аймаг хөгжүүлэх “Эрдэнэт сан” болон Жаргалант сумын ОНХС-ын хяналт шалгалтын удирдамж батлагдсан боловч хийгдээгүй, бусад шалгалтын удирдамж батлагдаагүй болон ирээгүйтэй холбоотой байна. Төлөвлөгөөт бус АИТХ-ын

“Төсвийн бодлого ИТХ-ын хяналт” 5-р сарын аяны хүрээнд СТСХ, АИТХ-ын Төсөв санхүүгийн хороотой хамтран 1, иргэний гомдлоор 2 хяналт шалгалт хийжээ.

Эдгээр хяналт шалгалтаар тайлант хугацаанд улсын байцаагчийн 86 заалт бүхий хугацаатай 46 албан шаардлага, 263 зөвлөмж хүргүүлэн, 38 байгууллагад 29.4 сая төгрөгийн 64 нөхөн төлбөрийн акт тогтоосон ба үүнээс 39 албан шаардлага, 20.8 сая төгрөгийн 58 нөхөн төлбөрийн актын биелэлт хангагдсан байна.

Сангийн яамнаас Засгийн газрын 2015 оны 483 тоот тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 8.5-д “санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэж заасны дагуу хөндлөнгийн үнэлгээг 11-р сард хийсэн байна.

Сангийн яамнаас 2016 оны 11-р сард хийсэн хөндлөнгийн үнэлгээгээр Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудитын чиглэлийн үйл ажиллагааны одоогийн хүрсэн түвшин, үйл ажиллагааг зохицуулахаар батлагдсан баримт бичгүүд, хууль, эрх зүйн орчин, ажлын гүйцэтгэл зэргийг харгалзан түүний чадавхийн түвшинг 2.0 буюу “Хөгжиж буй” гэж дүгнэсэн байна.

## **2.5 Шилэн дансны хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 8.2-д заасан ТЕЗ-ийн хяналтыг Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг байна. Тус алба нь 2017 онд нийт 4 удаа буюу улирал бүр шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд төлөвлөгөөт хяналт хийж, байгууллага тус бүрт бодит байдал, илэрсэн зөрчил, цаашид анхаарах асуудлыг тусгасан товч тайлан зөвлөмжийг хүргүүлж, тайланг аймгийн Засаг даргад тухай бүр холбогдох санал дүгнэлт, зөвлөмжийн хамт хүргүүлж танилцуулдаг байна.

Санхүүгийн хяналт, аудитын албанаас орон нутгийн төсвийн байгууллагууд болон ерөнхий боловсролын сургууль, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын удирдах ажилтан, дотоод хяналтын ажилтан, нягтлан бодогч нарт шилэн дансны хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллах үүднээс шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулах чадавхжуулах сургалтыг дангаар болон бусад сургалтын агуулгад оруулж тогтмол хүргэж ажилладаг байна.

Манай байгууллагын 2017 оны 11-р сард гүйцэтгэсэн “Шилэн дансны хуулийн хэрэгжилт” нийцлийн аудитаар Орхон аймгийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг дараах байдлаар дүгнэсэн байна.

1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны цахим хуудсанд бүрэн хамрагдсан хэдий ч нийт байгууллагуудын 81.1 хувь нь мэдээлэл хүргэх хэлбэрийг бүрэн баримталсан байна
2. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг 87.2 хувьтай мэдээлсэн байна.
3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа ч иргэдийн Төлөөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурлын хөндлөнгийн хяналт хэрэгжүүлээгүй байна.

## **2.6 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР**

Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн “Э-тайлан” програмаар нэгтгэн гаргасан Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг СТАУС програмд санхүүгийн тайлан татаж оруулах загвар файлд шивж СТАУС програмд оруулж, холбогдох үзүүлэлтүүдийн хоорондын уялдаа холбоог тулгаж баталгаажууллаа.

### **Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан**

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны нэгтгэсэн тайлан 8,740.0 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 8,658.5 сая төгрөгийн авлага болон урьдчилгаа, 5,293.6 сая төгрөгийн бараа



материал, нөөцийн бараа, 169,277.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, нийт 191,969.3 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Орхон аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн өмнөх оноос 7,577.0 сая төгрөгөөр буюу 4.1 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь мөнгөн хөрөнгө 2,746.9 сая төгрөгөөр буурсан ч авлага болон урьдчилгаа 2,195.8 сая төгрөгөөр, бараа материал, нөөцийн бараа 770.8 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө 7,357.3 сая төгрөгөөр тус тус өссөн, эх үүсвэр талаас БХӨТ 2,289.5 сая төгрөгөөр, УХӨТ 144.7 сая төгрөгөөр, Засгийн газрын хувь оролцоо 5,142.8 сая төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Тайлант оны нийт хөрөнгийн 11.8 хувийг эргэлтийн хөрөнгө, 88.2 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж байгаа бол өр төлбөр, цэвэр хөрөнгө, өмчийн дүнгийн 11.06 хувийг нийт өр төлбөр, 88.94 хувийг цэвэр хөрөнгө/өмчийн дүн эзэлж байна.

### **Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан**

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогын 47,023.9 сая төгрөг буюу 39.96 хувийг татварын орлого, 34,744.8 сая төгрөг буюу 29.53 хувийг татварын бус орлого, 35,902.9 сая төгрөг буюу 30.51 хувийг тусламж санхүүжилтийн орлого эзэлж байна.

Нэгтгэсэн нийт орлого өмнөх оноос 38,843.8 сая төгрөгөөр буурсан нь татварын бус орлого 41,829.2 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна. Бусад орлого 407.7 сая төгрөгөөр нэмэгдсэн ч торгуулийн орлого 150.0 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлого 648.7 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 41,350.0 сая төгрөгөөр тус тус буурсан нь татварын бус орлогын бууралтанд нөлөөлжээ. Татварын орлого өмнөх оноос 2,791.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Зардлын хувьд цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 698.3 сая төгрөгөөр, БГАҮТХ-ийн зардал 806.0 сая төгрөгөөр тус тус өссөн бол хангамж, бараа материалын зардал 14,173.2 сая төгрөгөөр /үүний дотор бараа материал шилжүүлсний зардал 14,219.1 сая төгрөгөөр буурсан/, бараа үйлчилгээний бусад зардал 7,847.4 сая төгрөгөөр тус тус буурсан зэрэг нийтдээ урсгал зардал өмнөх оноос 14,428.5 сая төгрөгөөр буурсан байна.

### **Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан**

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайланд Засгийн газрын хувь оролцоо 5,142.8 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын оруулсан капитал 3,692.9 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр дүн 1,449.9 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

### **Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан**

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2,746.9 сая төгрөгөөр буурсан байна.

Үйл ажиллагааны мөнгөн орлого өмнөх оноос 3,449.8 сая төгрөгөөр нэмэгдсэн бол үйл ажиллагааны мөнгөн зарлага 5,610.4 сая төгрөгөөр өссөн, хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний зардал 11,990.3 сая төгрөгөөр буурсан байна.

## **2.7 САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

### **Нэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 11,486.8 сая төгрөгөөс, эцсийн үлдэгдэл 8,739.9 сая төгрөг болж, тайлант онд 23.9 хувь буюу 2,746.9 сая төгрөгөөр буурсан байна.

Орхон аймгийн ТЕЗ-ийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	<b>2.7</b>	<b>0.02</b>	<b>9.7</b>	<b>0.11</b>	<b>7.0</b>	<b>0,06</b>
<i>Төгрөг</i>	2.7	0.02	9.7	0.11	7.0	0,06
<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>11,484.1</b>	<b>99.98</b>	<b>8,730.2</b>	<b>99.89</b>	<b>-2,753.9</b>	<b>-23.97</b>
<i>Төгрөг</i>	11,484.1	99.98	8,730.2	99.89	-2,753.9	-23.97
- Төрийн сангийн харилцах	11,148.4	97.06	8,297.0	94.93	-2,851.4	-24.82
- Арилжааны банк дахь харилцах	335.7	2.92	433.2	4.96	97.5	0.85
<b>Нийт дүн</b>	<b>11,486.8</b>	<b>100</b>	<b>8,739.9</b>	<b>100</b>	<b>-2,746.9</b>	<b>-23.91</b>
<b>Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:</b>						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		Үүнээс:		
		Дүн	Хувь	Касс	Төрийн сан	Арилжааны банк
- Төсөвт байгууллага	1,581.8	2,236.3	25.59	1.0	2,234.6	0.75
- Төрийн сан	9,673.5	6,170.5	70.60		6,062.4	108.0
- Төсөл сан	0	0	0			
- Орон нутгийн өмчит аж	231.5	333.1	3.81	8.7		324.45
<b>Нийт дүн</b>	<b>11,486.8</b>	<b>8,739.9</b>	<b>100</b>	<b>9.7</b>	<b>8,297.0</b>	<b>433.2</b>

Банкан дахь төгрөгийн харилцах дансны үлдэгдэл 23.97 хувь буюу 2,753.9 сая төгрөгөөр буурсан бол кассанд байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл 3,5 дахин буюу 7.0 сая төгрөгөөр өссөн нь мөнгөн хөрөнгийн өөрчлөлтөнд 0.06 хувийн нөлөөллийг үзүүлж байна. Төрийн сангийн харилцах 2,851.4 сая төгрөгөөр буурч, арилжааны банкны харилцах 97.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдлийн 3.81 хувийг ОНӨААН, 70.60 хувийг төрийн сан, 25.59 хувийг төсвийн байгууллагууд бүрдүүлж байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 0.11 хувийг кассанд байгаа бэлэн мөнгө, 99.89 хувийг банканд байгаа бэлэн мөнгө эзэлж байна. Үүний 94.93 хувь нь төрийн сангийн харилцах, 4.96 хувь нь арилжааны банкны харилцах байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг өмнөх онтой харьцуулбал төрийн сангийн мөнгөн хөрөнгө 3,503.0 сая төгрөгөөр буурч, төсөвт байгууллагынх 654.5 сая төгрөгөөр, ОНӨААН-ийнх 101.6 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Нийт мөнгөн хөрөнгийн бууралтанд төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн бууралт буюу орон нутгийн төсвийн шилжих үлдэгдэл буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Төрийн сангийн арилжааны банкан дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хуучин төсвийн байгууллагуудын бэлэн мөнгөний гүйлгээг дамжуулж гаргадаг байсан гэх Төрийн банкан дахь сар бүр хүү тооцож олгодог 97.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй болон 9.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй данс багтаж байна. Уг данснаас урьдчилж мөнгө гаргаж авах зэргээр зориулалт бусаар ашиглаж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэсэн заалт болон Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан 2013 оны 24/24/А-9 тоот хавсралтаар баталсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг монголбанк, банкинд нээх, хаах журам”-тай нийцэхгүй байна. Төрийн сангийн Төрийн банканд байршиж буй дансны зориулалтыг тодорхой болгох, үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлэх, зориулалтын дагуу ашиглах.

Аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой анхан шатны баримтын бүрдэл бүрэн хангуулаагүй ажил гүйлгээг бүртгэсэн, бүртгэл, тайлагнал, баталгаажуулалт, санхүүгийн

сахилга, хариуцлагатай холбоотой нийт 39.74 сая төгрөгийн алдаа, зөрчлийг аудитаар илрүүлсэн байна.

**Шийдвэрлэсэн :** Дээрх алдаа зөрчлүүдээс 16.7 сая төгрөгийн залруулгыг холбогдох байгууллагуудаар аудитын явцад хийлгэж, 0.44 сая төгрөгийн албан шаардлага, 22.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж холбогдох байгууллагын төсвийн захирагч нарт хүргүүлж хүлээн зөвшөөрсөн болно.

### Хоёр. Авлага

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт авлагын эхний үлдэгдэл 6,379.9 сая төгрөг байснаас тайлант онд 2251.8 сая төгрөгөөр буюу 35.29 хувиар өсч, оны эцэст 8,631.7 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

(сая.төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт / (Бууралт)	Өөрчлөл- тийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
Ажиллагчидтай холбогдсон авлага	7.47	0.12	8.70	0.10	1.23	0.02
Төлбөртэй үйлчилгээний авлага	1,568.28	24.58	1,598.88	18.52	30.60	0.48
Татаас, санхүүжилтийн авлага	2.44	0.04	11.10	0.13	8.66	0.14
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	33.26	0.52	13.94	0.16	-19.32	-0.30
Байгууллагаас авах авлага	3,701.96	58.02	5,823.55	67.47	2,121.59	33.25
Хувь хүмүүсээс авах авлага	240.15	3.76	241.85	2.80	1.70	0.03
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	615.00	9.64	615.00	7.12	0.00	0.00
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	211.39	3.31	318.69	3.69	107.30	1.68
<b>Нийт дүн</b>	<b>6,379.94</b>	<b>100.00</b>	<b>8,631.70</b>	<b>100.00</b>	<b>2,251.75</b>	<b>35.29</b>
<b>Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:</b>						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт / (Бууралт)	Өөрчлөл- тийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
- Төсөвт байгууллага	1,541.99	24.17	1724.57	19.98	182.57	2.86
- Төрийн сан	746.32	11.70	744.67	8.63	-1.65	-0.03
- Төсөл сан	222.50	3.49	221.20	2.56	-1.30	-0.02
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	3,869.13	60.65	5941.26	68.83	2,072.13	32.48
<b>Нийт дүн</b>	<b>6,379.94</b>	<b>100.00</b>	<b>8,631.70</b>	<b>100.00</b>	<b>2,251.75</b>	<b>35.29</b>

Дээрх хүснэгтээс нийт авлагын эцсийн үлдэгдлийн 0.10 хувийг ажиллагчидтай холбогдсон авлага, 18.52 хувийг төлбөртэй үйлчилгээний авлага, 0.13 хувийг татаас, санхүүжилтийн авлага, 0.16 хувийг татвар, ндш-ын авлага /ТӨҮГ/, 67.47 хувийг байгууллагаас авах авлага, 2.80 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 7.12 хувийг засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээл, 3.69 хувийг хувийн хэвшлийн аж ахуй нэгжид олгосон зээл тус тус бүрдүүлж байна.

Байгууллагаас авах авлага 2,121.59 сая төгрөг буюу 33.25 хувиар нэмэгдэж өмнөх онд нийт авлагын 58.02 хувийг эзэлж байсан бол тайлант онд 67.47 хувийг эзэлж байна. Авлага өссөнтэй холбоотойгоор зарим нэр төрлийн авлагын дүн нэмэгдсэн ч авлагын дүнд эзлэх хувь буурсан байна. Тухайлбал төлбөртэй үйлчилгээний авлага 0.48 хувиар буюу 30.6 сая төгрөгөөр нэмэгдсэн ч авлагын дүнд эзлэх хувь 24.58-с 18.52 хувь болж буурчээ. Мөн засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээлийн авлага өөрчлөгдөөгүй боловч дүнд эзлэх хувь 9.64-с 7.12 хувь болон буурч байна.

Байгууллагын төрлөөр харвал авлагын эцсийн үлдэгдлийн 68.83 хувь буюу 5,941.26 сая төгрөгийг орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн авлага, 19.98 хувь буюу 1,724.56 сая төгрөгийг төсөвт байгууллагын авлага, 8.63 хувь буюу 744.67 сая төгрөгийг төрийн сангийн авлага, 2.56 хувь буюу 221.2 сая төгрөгийг төсөл сангийн авлага тус тус эзэлж байна.

Нийт авлагын өсөлтөд ОНӨААН-ийн авлага 32.48 хувиар буюу 2,072.13 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын авлага 2.86 хувь буюу 182.57 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Авлагын ангиллаар авч үзвэл эдгээр нь ихэвчлэн байгууллагаас авах авлага болжээ. Төрийн сангийн болон, төсөл сангийн авлага 2.95 сая төгрөгөөр буурсан байна.

Аудитаар авлагын данстай холбоотой НББ-ийн холбогдох стандарт, журам, зааврыг мөрдөөгүй, дансны бичилт буруу хийсэн, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлагыг хугацаанд нь барагдуулаагүй зэрэг нийт 180.8 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн байна.

**Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчлүүдээс 16.6 сая төгрөгийн залруулгыг холбогдох байгууллагуудаар аудитын явцад хийлгэж, 151.16 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж, 13.06 сая төгрөгийн албан шаардлагыг холбогдох байгууллагын төсвийн захирагч нарт хүргүүлж хүлээн зөвшөөрсөн болно.

### Гурав. Урьдчилгаа

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 82.7 сая төгрөг байснаас тайлант онд 55.9 сая төгрөгөөр буурч, оны эцэст 26.8 сая төгрөгөөр тайлагнагдсан байна. Нийт урьдчилгаа дансны үлдэгдэлд урьдчилж гарсан зардал 100 хувийг эзэлж байна.

### Дөрөв. Бараа материал

Орхон аймгийн ТЕЗ-ийн бараа материалын эхний үлдэгдэл 4,505.2 сая төгрөг байснаас 709.6 сая төгрөгөөр өсч, 5,214.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Бараа материалын үлдэгдлийг ангилал, байгууллагын төрлөөр харуулбал:  
(сая.төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
<b>Түүхий эд материал</b>	<b>2,792.22</b>	<b>61.98</b>	<b>3,409.27</b>	<b>65.38</b>	<b>617.06</b>	<b>13.70</b>
- Тусгай зориулалттай материал	2,784.27	61.80	3,395.01	65.10	<b>610.75</b>	13.56
- Эм боох материал	7.95	0.18	14.26	0.27	<b>6.31</b>	0.14
<b>Дуусаагүй үйлдвэрлэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>49.72</b>	<b>0.95</b>	<b>49.72</b>	<b>1.10</b>
<b>Бэлэн бүтээгдэхүүн</b>	<b>10.61</b>	<b>0.24</b>	<b>9.61</b>	<b>0.18</b>	<b>-0.99</b>	<b>-0.02</b>
<b>Хангамжийн материал</b>	<b>1,682.58</b>	<b>37.35</b>	<b>1,726.47</b>	<b>33.11</b>	<b>43.89</b>	<b>0.97</b>
- Бичиг хэргийн материал	64.61	1.43	58.41	1.12	<b>-6.20</b>	-0.14
- Аж ахуйн материал	570.38	12.66	619.52	11.88	<b>49.14</b>	1.09
- Сэлбэг хэрэгсэл	58.79	1.30	74.17	1.42	<b>15.38</b>	0.34
- Түлш, шатах тослох материал	21.55	0.48	10.93	0.21	<b>-10.62</b>	-0.24
- Барилгын засварын материал	24.28	0.54	17.09	0.33	<b>-7.19</b>	-0.16
- Хүнсний материал	32.22	0.72	15.62	0.30	<b>-16.60</b>	-0.37
- Бусад хангамжийн материал	910.75	20.22	930.74	17.85	<b>19.98</b>	0.44

<i>Мал амьтад</i>	<i>19.80</i>	<i>0.44</i>	<i>19.80</i>	<i>0.38</i>	<i>0.00</i>	<i>0.00</i>
<b>Нийт дүн</b>	<b>4,505.21</b>	<b>100.00</b>	<b>5,214.87</b>	<b>100.00</b>	<b>709.67</b>	<b>15.75</b>
<b>Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:</b>						
<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>		<b>Эцсийн үлдэгдэл</b>		<b>Өсөлт (+) Бууралт (-)</b>	<b>Өөрчлөлтийн хувь</b>
	<b>Дүн</b>	<b>Хувь</b>	<b>Дүн</b>	<b>Хувь</b>		
- Төсөвт байгууллага	3,827.78	84.96	4,520.97	86.69	693.19	15.39
- Төрийн сан		0.00		0.00	0.00	0.00
- Төсөл сан		0.00		0.00	0.00	0.00
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	677.42	15.04	693.90	13.31	16.48	0.37
<b>Нийт дүн</b>	<b>4,505.21</b>	<b>100.00</b>	<b>5,214.87</b>	<b>100.00</b>	<b>709.67</b>	<b>15.75</b>

Нийт бараа материалын үлдэгдлийн 13.3 хувь буюу 693.9 сая төгрөгийг орон нутгийн өмчит ААН, 86.7 хувь буюу 4,520.9 сая төгрөгийг төсөвт байгууллагууд эзэлж байна.

Тайлант оны бараа материалын өсөлтөд түүхий эд материал 13.7 хувиар буюу 617.06 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн байна. Энэ нь тусгай зориулалтын материалын өсөлт буюу төсөвт байгууллагын бараа материалын өсөлт байна.

Тайлант онд нийт 7,053.1 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэнээс төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдан авсан 5,852.4 сая төгрөг, хандив, тусламжаар хүлээн авсан 365.7 сая төгрөг, шилжүүлэн авсан 458.0 сая төгрөг, бусад хэлбэрээр хүлээн авсан 377.0 сая төгрөг байна. Харин нийт 6,343.4 сая төгрөгийн бараа материал хасагдсаны 5,932.7 сая төгрөгийг худалдан зарцуулсан, 133.4 сая төгрөгийг шилжүүлсэн, 17.0 сая төгрөгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн, 260.3 сая төгрөгийг бусад хэлбэрээр зарлагдсан байна.

Үүнээс ОНӨААН-үүд тайлант онд нийт 854.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 838.4 сая төгрөгийн бараа материал худалдан, зарцуулсан байна.

Аудитаар бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, данс бүртгэлд орлогоор тусгахгүй шууд зардлаар бүртгэсэн, бараа материалын нэр төрлийн хөдөлгөөний тайлан гаргаагүй, анхан шатны баримтгүй зарцуулсан, тооллогод хамруулаагүй, тушаал шийдвэргүй данс бүртгэлээс хассан, зориулалтын бус зүйлд зарцуулсан зэрэг нийт 481.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

**Шийдвэрлэсэн :** Дээрх зөрчлүүдээс 139.6 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад холбогдох байгууллагуудын санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 341.4 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж, албан шаардлагыг холбогдох байгууллагын удирдлагад өгснийг хүлээн зөвшөөрсөн болно.

#### **Тав. Нөөцийн бараа**

Орхон аймгийн ТЕЗ-ийн нөөцийн барааны эхний үлдэгдэл 17.6 сая төгрөг байснаас 61.1 сая төгрөгөөр өсч, 78.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь тэжээлийн нөөц байна.

#### **Зургаа. Үндсэн хөрөнгө**

Орхон аймгийн ТЕЗ-ийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр 161,919.9 сая төгрөг байснаас 4.5 хувиар буюу 7,357.3 сая төгрөгөөр өсч, тайлант оны эцэст 169,277.2 сая төгрөг болсон байна.

Нийт хөрөнгийн 99.5 хувийг биет хөрөнгө, 0.5 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

Хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр.

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
Газар	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>Биет хөрөнгө</b>	<b>161,682.5</b>	<b>99.9</b>	<b>168,420.2</b>	<b>99.5</b>	<b>6,737.7</b>	<b>4.2</b>
Барилга, байгууламж	95,393.2	58.9	103,581.6	61.2	8,188.4	5.1
Авто тээврийн хэрэгсэл	3,938.3	2.4	3,069.3	1.8	-869.0	-0.5
Машин тоног төхөөрөмж	8,256.6	5.1	8,349.2	4.9	92.6	0.1
Тавилга эд хогшил	2,407.2	1.5	2,491.1	1.5	83.9	0.1
Зам, гүүрийн байгууламж	30,021.1	18.5	28,470.8	16.8	-1,550.3	-1.0
Түүх, соёл, музейн дурсгалт зүйлс	651.3	0.4	657.3	0.4	6.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	11,548.6	7.1	12,365.9	7.3	817.3	0.5
Дуусаагүй барилга	9,332.6	5.8	9,278.5	5.5	-54.1	0.0
Ном	133.6	0.1	156.4	0.1	22.8	0.0
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>237.4</b>	<b>0.1</b>	<b>857.0</b>	<b>0.5</b>	<b>619.6</b>	<b>0.4</b>
Программ хангамж	237.4	0.1	215.9	0.1	-21.5	0.0
Бусад биет бус хөрөнгө	0.0	0.0	641.1	0.4	641.1	0.4
<b>Нийт дүн</b>	<b>161,919.9</b>	<b>100.0</b>	<b>169,277.2</b>	<b>100.0</b>	<b>7,357.3</b>	<b>4.5</b>

Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:


Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт (+) Бууралт (-)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
- Төсөвт байгууллага	134,724.9	83.2	138,895.0	82.1	4,170.1	2.5
- Төрийн сан		0.0		0.0	0.0	0.0
- Төсөл сан		0.0		0.0	0.0	0.0
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	27,195.0	16.8	30,382.2	17.9	3,187.2	2.0
<b>Нийт дүн</b>	<b>161,919.9</b>	<b>100.0</b>	<b>169,277.2</b>	<b>100.0</b>	<b>7,357.3</b>	<b>4.5</b>

Тайлант оны үндсэн хөрөнгийн дансны цэвэр өсөлт 18,316.5 сая төгрөг, хуримтлагдсан элэгдлийн цэвэр өсөлт 10,959.2 сая төгрөг буюу хуримтлагдсан элэгдлийг хассан цэвэр дүнгээр нийт үндсэн хөрөнгө 7,357.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд 3 байгууллага ашиглалтанд орсон болон улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн өсөлтийн 2.6 хувь буюу 4,170.1 сая төгрөгийг төсөвт байгууллагын, 2.0 буюу 3,187.2 сая төгрөгийг ОНӨААН-үүдийн үндсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна. Хөрөнгийн ангиллаар харвал биет хөрөнгө 4.2 хувь буюу 6,737.7 сая төгрөгөөр, биет бус хөрөнгө 0.4 хувь буюу 619.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт үндсэн хөрөнгийн 61.2 хувийг барилга, байгууламж, 16.8 хувийг зам, гүүрийн байгууламж, 7.3 хувийг бусад үндсэн хөрөнгө, 5.5 хувийг дуусаагүй барилга, байгууламж, 1.5 хувийг тавилга, эд хогшил, 4.9 хувийг машин, тоног төхөөрөмж, 1.8 хувийг тээврийн хэрэгсэл, 0.4 хувийг түүх, соёл, музейн дурсгалт зүйлс, 0.5 хувийг биет бус хөрөнгө тус тус эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн бүтцийг диаграммаар харуулбал:



Аудитаар үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй, зөрүүтэй бүртгэсэн, хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй, үндсэн хөрөнгийн элэгдлийг зөрүүтэй тооцсон, төсвийн урсгал зардлаас болон холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр үндсэн хөрөнгө бэлтгэсэн зэрэг 872.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

**Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчилд 317.6 сая төгрөгийн алдааг дахин давтахгүй байх зөвлөмж, 59.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 495.3 сая төгрөгийн залруулга хийсэн бөгөөд холбогдох байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

### Долоо. Өр төлбөр

Нийт өр төлбөр оны эхэнд 18,794.3 сая төгрөг байснаас тайлант онд 2,434.2 сая төгрөгөөр өсч, 21,228.5 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт өр төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

(сая.төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт/ (Бууралт)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>7,155.85</b>	<b>38.07</b>	<b>9,445.39</b>	<b>44.49</b>	<b>2,289.54</b>	<b>12.18</b>
<b>Богино хугацаат зээлийн өглөг</b>	<b>19.30</b>	<b>0.10</b>	<b>26.90</b>	<b>0.13</b>	<b>7.59</b>	<b>0.04</b>
<b>Өглөг</b>	<b>408.94</b>	<b>2.18</b>	<b>20.30</b>	<b>0.10</b>	<b>-388.64</b>	<b>-2.07</b>
- Ажилчидтай холбогдсон өглөг	9.91	0.05	14.22	0.07	4.31	0.02
- Бараа, үйлчилгээний зардлын өглөг	28.03	0.15	6.08	0.03	-21.95	-0.12
- Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	371.00	1.97	0.00	0.00	-371.00	-1.97
<b>Бусад өглөг</b>	<b>4,556.57</b>	<b>24.24</b>	<b>6,426.01</b>	<b>30.27</b>	<b>1,869.44</b>	<b>9.95</b>
- Байгууллагад төлөх өглөг	2,171.61	11.55	1,535.46	7.23	-636.15	-3.38
- Хувь хүмүүст төлөх өглөг	161.16	0.86	389.47	1.83	228.31	1.21
- Татварын өглөг /ТӨҮГ/	8.06	0.04	157.46	0.74	149.40	0.79
- НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.65	0.00	3.61	0.02	2.96	0.02
- Дансны өглөг /ТӨҮГ/	2,215.09	11.79	4,340.01	20.44	2,124.92	11.31
<b>Урьдчилж олсон орлого</b>	<b>2,171.04</b>	<b>11.55</b>	<b>2,972.19</b>	<b>14.00</b>	<b>801.15</b>	<b>4.26</b>
- Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	1,639.27	8.72	2,278.48	10.73	639.22	3.40
- Бусад урьдчилж орсон орлого	531.77	2.83	538.37	2.54	6.60	0.04

- Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар	0.00	0.00	155.33	0.73	155.33	0.83
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>11,638.52</b>	<b>61.93</b>	<b>11,783.19</b>	<b>55.51</b>	<b>144.66</b>	<b>0.77</b>
- Хойшлогдсон өр төлбөр	4,191.81	22.30	4,336.48	20.43	144.66	0.77
- Төслийн зээл /ТӨҮГ/	7,446.71	39.62	7,446.71	35.08	0.00	0.00
<b>Нийт дүн</b>	<b>18,794.38</b>	<b>100.00</b>	<b>21,228.58</b>	<b>100.00</b>	<b>2,434.20</b>	<b>12.95</b>
<b>Үүнийг байгууллагын төрлөөр харуулбал:</b>						
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өсөлт/ (Бууралт)	Өөрчлөлтийн хувь
	Дүн	Хувь	Дүн	Хувь		
- Төсөвт байгууллага	3,656.76	19.46	3,868.78	18.22	212.02	1.13
- Төрийн сан	7,904.66	42.06	7,565.15	35.64	-339.51	-1.81
- Төсөл сан	222.50	1.18	221.20	1.04	-1.30	-0.01
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	7,010.46	37.30	9,573.45	45.10	2,562.99	13.64
<b>Нийт дүн</b>	<b>18,794.38</b>	<b>100.00</b>	<b>21,228.58</b>	<b>100.00</b>	<b>2,434.20</b>	<b>12.95</b>

Нийт өр төлбөрт урт хугацаат өр төлбөр 11,783.2 сая төгрөг буюу 55.5 хувийг, богино хугацаат өр төлбөр 9,445.3 сая төгрөг буюу 45.5 хувийг тус тус эзэлж байна. Тайлант онд БХӨТ 2,289.5 сая төгрөг буюу 12.1 хувиар, урт хугацаат өр төлбөр 144.6 сая төгрөг буюу 0.8 хувиар нэмэгдсэн байна.

### 7.1. Богино хугацаат өр төлбөр

БХӨТ-ийн өсөлтөнд бусад өглөг 1,869.4 сая төгрөгөөр, урьдчилж олсон орлого 801.1 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Бусад өглөгийн өсөлт нь дансны өглөг /ТӨҮГ/-ийн 2,124.9 сая төгрөгийн өсөлттэй холбоотой бол урьдчилж орсон орлогын өсөлт нь Эрдэнэт санд хаагдсан хөрөнгө оруулалтын он дамжин хийгдэх ажлын үлдэгдэл, “Эрдэнэт ШУТПарк” ОНӨААТҮГ-ын УОО-ын бүртгэлтэй холбоотой байна.

Тайлант онд байгууллагад төлөх өглөг 636.1 сая төгрөгөөр буурсан бол хувь хүнд төлөх өглөг 228.3 сая төгрөгөөр, татварын өглөг /ТӨҮГ/ 149.4 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Аудитаар өглөгийн данстай холбоотой өглөгийг буруу бүртгэсэн, бараа, ажил үйлчилгээг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн, үлдэгдлийг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зэрэг нийт 124.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн: Дээрх алдаа зөрчилд 6.7 сая төгрөгийн алдааг дахин давтахгүй байх зөвлөмж, 10.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 107.7 сая төгрөгийн залруулга хийсэн бөгөөд холбогдох байгууллагын удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

### 7.2. Урт хугацаат өр төлбөр

*Төслийн зээл:* МОН-23 төслийн зээлийн өглөг 7,446.7 сая төгрөг орон нутгийн өр төлбөрт бүртгэлтэй байдаг байна. Энэ нь орон нутагт гэр хорооллын ус цэвэрлэх байгууламжийг сэргээн засварлах, газар доорх ус хангамж, ариутгалын систем, дэд бүтцийн тоног төхөөрөмжийг шинэчилж сайжруулах, төвлөрсөн системд холбож, худаг гаргахад зориулан Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн зээлийн өглөг байна.

*Хойшлогдсон өр төлбөр:* “Эрдэнэт Ус ДТС” ОНӨХК-д сүүлийн жилүүдэд аймгийн хэмжээнд хийгдсэн гудамжны гэрэлтүүлгийн хөрөнгө оруулалтын ажлуудыг өмчлүүлснээс шалтгаалан үндсэн хөрөнгийн элэгдэл нэмэгдэж, тус байгууллага нь алдагдалтай ажилласнаас шалтгаалан хойшлогдсон өр төлбөр бүртгэсэн байна.

Мөн Франц улын хөрөнгө оруулалтаар Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийн өргөтгөлийн төсөл хэрэгжиж байгаа бөгөөд энэ төслийг эцсийн байдлаар орон нутаг хүлээж аваагүй байгаа тул хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн тайланд бүртгэлгүй, тайлбар тодруулгаар оруулсан байна.



**Найм. Засгийн газрын хувь оролцоо**

Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нийт хэмжээ тайлант оны эхэнд 165,597.9 сая төгрөг байснаас 3.1 хувь буюу 5,142.8 сая төгрөгөөр нэмэгдэж 170,740.7 сая төгрөгт хүрсэн байна.

Засгийн газрын хувь оролцооны бүтцийг авч үзвэл, Засгийн газрын оруулсан капитал 43.7 хувь буюу 74,643.1 сая төгрөг, дахин үнэлгээний нөөц 15.1 хувь буюу 25,864.4 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 41.2 хувь буюу 70,233.2 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

**Ес. Орлогын талаар**

Орхон аймаг 2017 оны төсвийн орлогыг Аймгийн ИТХ-ийн 2016 оны 12-р сарын 05-ны өдрийн хуралдаанаар 44,409.4 сая төгрөгөөр баталсан байна. 2017 онд аймгийн ИТХ-аар төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тодотголыг 2 удаа хийж, орон нутгийн нийт орлогыг 44,562.8 сая төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогыг 1,073.5 сая төгрөгөөр, ХХОАТ-ын буцаалтыг 300.0 сая төгрөгөөр тус тус бууруулж хадгаламжийн хүүгийн орлогыг 926.9 сая төгрөгөөр шинэчлэн тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр 47,579.3 сая төгрөгийн орлого төвлөрч орлогын гүйцэтгэл 107.2%-иар биелсэн байна.

15 нэр төрлийн орлого төрийн сангийн 35 дансаар дамжин орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрсөн байна.

Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

(сая.төгрөг)

Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө 2016.12.05	Төлөвлөгөө 2017-05-26	Төлөвлөгөө 2017-12-01	2017 оны орлогын гүйцэтгэл
910-Эхний үлдэгдэл				9,472.88
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	29,507.95	29,507.95	28,434.40	27,748.81
Үйл ажиллагааны орлого	370.00	370.00	370.00	196.68
Шууд бус орлого	411.00	411.00	411.00	922.26
Хадгаламжийн хүү.орлого	-	1,505.41	926.96	716.22
Хөрөнгө борлуулсны орлого	850.00	850.00	850.00	598.25
Үл хөдлөх хөрөнгийн татвар	5,500.00	5,500.00	5,500.00	6,931.55
Бууны татвар	10.50	10.50	10.50	36.64
АТБӨЯХАТатвар	702.00	702.00	702.00	851.49
Улсын тэмдэгтийн хураамж	310.00	310.00	310.00	396.92
ТТАМ-н ОАТ	9.00	9.00	9.00	31.57
Газрын төлбөр	8,300.00	8,300.00	8,300.00	9,192.80
Хог хаягдлын хураамж	465.00	465.00	465.00	543.47
Бусад татвар	-	-	-	119.61
Ус рашааны нөөц ашигласны	21.00	21.00	21.00	546.93
Ойн нөөц ашигласны	3.00	3.00	3.00	10.71
Хүүгийн орлого	-		-	31.13
Торгуулийн орлого	450.00	450.00	450.00	895.32
ХХОАТ-ын буцаалт	- 2,500.00	- 2,500.00	- 2,200.00	- 2,191.02
<b>ДҮН</b>	<b>44,409.45</b>	<b>45,914.87</b>	<b>44,562.87</b>	<b>47,579.33</b>

Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь задлан үзвэл цалин хөлс, үйл ажиллагааны орлого, хадгаламжийн хүүгийн орлого, хөрөнгө борлуулсаны орлого тасарч, бусад орлогууд давж биелэсэн байна. Тасарсан орлого тус бүрийн шалтгааныг тогтооход дараах байдалтай байна. Үүнд:

1. **Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татвар:** Энэ төрлийн орлогыг бүрдүүлэгч гол аж ахуйн нэгж болох "Эрдэнэт Үйлдвэр"ХХК нь 2017 онд гадаад ажилтны тоогоо 50% хүртэл бууруулах арга хэмжээ авсан, мөн ахмад ажилтан тэтгэвэрт гарахад оронд нь шинээр ажилтан авах асуудал нь шийдэгдэхгүй удаашралтай байсан зэргээс шалтгаалан үйлдвэрийн цалингийн сан буурч, төлсөн ХХОАТ буурснаас шалтгаалсан байна.

2. **Үйл ажиллагааны орлого буюу аж ахуй эрхэлсний орлогын татвар:** Эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож, борлуулалт буурсантай холбоотой энэ төрлийн татварын орлого буурч, төлөвлөгөө тасарсан байна.

3. **Хөрөнгө борлуулсны татварын орлого:** Ипотекийн зээл олголт буурч үүнийг дагаад орон сууц, үл хөдлөх хөрөнгийн борлуулалт буурсантай холбоотой тасарсан.

4. **Хөрөнгийн орлого:** Энэ нь иргэдийн хадгаламжийн хүүгээс авдаг татварын орлого бөгөөд хууль нь 2017 оны 5-р сараас мөрдөгдөж эхэлсэн.Монгол банкнаас арилжааны банкууд дээр байгаа хадгаламжуудын судалгааг авсан боловч тухайн төрлийн татварын төсвийг өндөр төлөвлөснөөс орлого тасрахад хүрсэн.

**Ус рашааны нөөц ашигласны татвар:** Тайлант онд 21.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээрээ 525.9 сая төгрөгөөр давж биелсэн байна. Орлого өндөр дүнгээр давж биелэх болсон шалтгаан нь Сэлэнгэ голын сав газрын захиргаанаас төлөвлөгөөт шалгалтыг хийж "Эрдэнэт үйлдвэр" ХХК ус бохирдуулсан байхыг тогтоож нөхөн төлбөр тавигдсанаас үүдэн орлого үлэмж хэмжээгээр давсан байна. Үүнийг жил бүр төлөвлөх боломжгүй байдаг байна.

2017 онд бэлэн бус торгуулийн системээр давхардсан тоогоор 16014 иргэнд 1,076.2 сая төгрөгийн торгууль ноогдуулсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн орлогод 512.6 сая төгрөгийн орлого төвлөрч 563.5 сая төгрөгийн орлого ороогүй байна. Цагдаагийн газраас бэлэн бусаар тавьсан торгууль нь 15 хоногийн дотор төлөгдсөн байхаар тавигддаг байна. Цаашид уг орлогыг тухайн онд орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлж ажиллах бүрэн боломжтой байна.

Орлогын данстай холбоотой орлогыг дутуу төвлөрүүлсэн, ангилал алдаатай тайлагнасан, төлөвлөлт буруу хийсэн зэрэг 455.1 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн.

**Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчилд 383.0 сая төгрөгийн залруулга хийлгэж, 3.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 68.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж, албан шаардлагыг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, хүлээн зөвшөөрсөн болно.

## Арав. Зардлын талаар

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлагын төлөвлөгөө 92,964.27 сая төгрөг, гүйцэтгэлээр 89,123.13 сая төгрөг зарцуулж, 3,841.14 сая төгрөг хэмнэж, 95.87 хувийн биелэлттэй ажиллажээ.

Төсвийн зарлагыг хүснэгтээр харуулбал:

(сая.төгрөг)

ТГ-ийн тайлангийн Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2017 он			
			Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Дүнд эзлэх хувь
А	Б	1	2	3	4=3-2	5
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	94,652.76	92,964.27	89,123.13	-3,841.14	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	64,422.74	71,855.04	71,119.99	-735.41	79.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	43,073.04	45,196.01	44,543.49	-652.73	49.98
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	24,836.73	25,554.16	25,529.30	-24.86	28.64

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,721.21	2,838.92	2,821.90	-17.02	3.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,372.96	2,547.67	2,417.06	-130.61	2.71
2104	Хангамж, бараа материалын зардал	1,014.97	1,120.64	1,114.80	-5.84	1.25
2105	Нормативт зардал	2,103.82	2,101.85	2,090.70	-11.15	2.35
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	571.91	537.43	535.90	-1.53	0.60
2107	Томилолт, зочны зардал	90.80	119.20	112.80	-6.40	0.13
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,467.17</b>	<b>7,113.72</b>	<b>6,818.23</b>	<b>-295.49</b>	<b>7.65</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,381.31	7,010.27	6,739.30	-270.97	7.56
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2.35	4.87	0.98	-3.89	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	18.06	35.00	31.20	-3.80	0.04
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7.11	7.40	5.90	-1.50	0.01
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1.13	1.61	1.50	-0.11	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18.45	12.33	12.05	-0.28	0.01
210807	Газрын төлбөр	38.38	42.45	27.20	-15.25	0.03
210808	Банк, СБ-ын үйлчилгээний хураамж	0.39	-0.21	0.10	0.31	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,893.47</b>	<b>3,262.42</b>	<b>3,102.80</b>	<b>-159.83</b>	<b>3.48</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,572.70	3,015.07	2,862.15	-153.13	3.21
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	320.77	247.35	240.65	-6.70	0.27
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>996.87</b>	<b>803.81</b>	<b>778.35</b>	<b>-25.46</b>	<b>0.87</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	996.87	803.81	778.35	-25.46	0.87
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,352.83</b>	<b>25,855.22</b>	<b>25,798.15</b>	<b>-57.22</b>	<b>28.95</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>9,702.62</b>	<b>13,393.22</b>	<b>13,393.20</b>	<b>0.00</b>	<b>15.03</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	9,702.62	13,393.22	13,393.20	0.00	15.03
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,650.21</b>	<b>12,462.00</b>	<b>12,404.95</b>	<b>-57.20</b>	<b>13.92</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-0.14	0.00	0.00		0.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7,927.64	7,802.41	7,776.00	-26.56	8.72
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	331.61	211.64	210.70	-0.94	0.24
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	815.23	904.03	902.20	-1.83	1.01
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,226.08	627.87	611.00	-16.87	0.69
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан АХ-дад төрөөс үзүүлэх дэмжлэг	301.28	2,073.06	2,072.25	-0.81	2.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	48.51	842.99	832.80	-10.19	0.93
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,230.02</b>	<b>21,109.23</b>	<b>18,003.50</b>	<b>-3,105.73</b>	<b>20.20</b>
220001	Барилга байгууламж		19,465.55	16,450.90	-3,014.65	18.46
221001	Их засвар	27,713.81				0.00
222001	Тоног төхөөрөмж	2,516.22	1,643.68	1,552.60	-91.08	1.74

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлагын 79.8 хувь буюу 71,120.0 сая төгрөгийг урсгал зардал, 20.2 хувь буюу 18,003.5 сая төгрөгийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийн 28.64 хувийг цалин хөлсний зардал, 3.17 хувийг ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 2.71 хувийг тогтмол зардал, 1.25 хувийг хангамж бараа материалын зардал, 2.35 хувийг нормативт зардал, 0.60 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.13 хувийг томилолт, зочны зардал, 7.65 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, 3.48 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 0.87 хувийг хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, 28.95 хувийг урсгал шилжүүлэг тус тус эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийн урсгал зардал өмнөх оноос 6,697.25 сая төгрөгөөр өссөн бол хөрөнгийн зардал 12,226.52 сая төгрөгөөр буурч нийт төсвийн зардал өмнөх оноос 5,529.27 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвөөс улсын төсөвт 13,393.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Зардлын данстай холбоотой дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүй цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлын хооронд гүйлгэн зарцуулсан, цалин хөлс, зардлыг илүү, дутуу тооцож олгосон, тайлагнасан, төсвийг үрэлгэн, үр ашиггүй зарцуулсан, нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам, заавар мөрдөөгүй, дансны бичилт буруу хийсэн, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, ХХОАТ, НДШ илүү, дутуу тооцсон, сонгон шалгаруулалтгүйгээр худалдан авалт хийсэн зэрэг 2,132.3 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн.

**Шийдвэрлэсэн:** Дээрх алдаа зөрчилд 725.1 сая төгрөгийн залруулга хийлгэж, 15.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 816.0 сая төгрөгийн албан шаардлага, 575.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, хүлээн зөвшөөрсөн болно.

### **10.1 Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө болон хуваарилагдаагүй бусад зардлын талаар**

Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулахдаа урьдчилгаа төлбөрийг 80-100 хувь олгохоор тусгаж шилжүүлж байна. Энэ нь тус ажлыг хугацаандаа, үр дүнтэй, чанартай гүйцэтгэх, хийсэн ажлын тайлан, баримтыг бүрэн гүйцэд гаргуулан авч, үлдэгдэл санхүүжилтээр дамжуулан хяналт тогтоох, үнэлэлт дүгнэлт өгөх боломжийг алдагдуулж байна. Тухайн хариуцлагагүй ТББ-ийн холбогдох хүмүүсийн зориулалт бусаар зарцуулсан үйл ажиллагаа болж хувирч байна. Нөгөө талаар ТББ-тай гэрээ байгуулж, хамтран ажиллаж буй хэлтэс албад тухайн ажилд зарцуулагдах зардлыг, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах зарчимд нийцүүлж үндэслэлтэй боловсруулдаггүй байна. Тиймдээ ч үлдэгдэл санхүүжилтийг авалгүй орхидог, гүйцэтгэлийн тайлан, баримтыг цаг хугацаанд нь бүрэн ирүүлдэггүй байна. Тухайлбал үүнд:

1. "Бүрэнбүстийн иргэн - Эрдэнэтийн хөгжил" ТББ-тай 3.0 сая төгрөгийн гэрээ байгуулж урьдчилгаа 2.4 сая төгрөг олгосон. Тус ТББ нь гүйцэтгэлийн тайлан, баримтад хонины шулсан мах, компот, шоколад, нухаш, талх, хэд хэдэн шатахууны баримт зэрэг хувийн хэрэглээний баримтуудыг хавсаргаж тайлан ирүүлсэн үлдэгдэл санхүүжилтийг аваагүй.

2. "Эрдэнэтийн эрхэм залуус" ТББ-тай 3.0 сая төгрөгийн гэрээ байгуулж урьдчилгаа 2.4 сая төгрөг олгосон. Тус ТББ нь мөн гүйцэтгэлийн тайлан, баримтыг дутуу ирүүлсэн, үлдэгдэл санхүүжилтийг аваагүй, ихэнх нь шатахууны баримт хавсаргасан.

3. "Бид зорилготой залуус" ТББ-тай 2.0 сая төгрөгийн гэрээ байгуулж урьдчилгаа 1.6 сая төгрөг олгосон. Холбогдох зурагтай, гүйцэтгэсэн ажлын тайлан ирүүлсэн боловч зарцуулалтын санхүүгийн баримт ирүүлээгүй, үлдэгдэл санхүүжилтийг аваагүй

Хамтран ажиллах гэрээ болон аймгийн Засаг даргын захирамжаар тус сангаас олгогдсон дараах ажлуудын гүйцэтгэл гараагүй, холбогдох арга хэмжээ зохион байгуулагдаагүй, төсвийн хөрөнгө үр ашиггүй, зориулалт бусаар нийт 6.4 сая төгрөг зарцуулагдсан байна.

1. Аймгийн Засаг даргын 2017.09.13-ны өдрийн А/538 тоот захирамжаар БСУГ-ын мэргэжилтэн Д.Отгонбаатарт "Вашингтоны монгол сум" байгууллагын урилгаар АНУ-ын Вашингтон хотод болох "Монголын од" бага хуралд оролцоход дэмжлэг үзүүлсэн 2.5 сая төгрөг. Тухайн арга хэмжээнд явж оролцоогүй, визэнд ороогүй.

2. "Монголын үндэсний гэрэл зураг, дүрс бичлэгийн хөгжил" ТББ-тай хамтран ажиллах гэрээний урьдчилгаанд /80%/ олгосон 3.9 сая төгрөг. Холбогдох үүргийн биелэлт хангагдаагүй, гэрээнд тусгагдсан арга хэмжээг зохион байгуулаагүй, гэрээний ТББ-ын үүрэг

болох 2.1-2.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Аймгийн ЗД-ын 2017.12.14-ны өдрийн А/738 тоот захирамжаар 13.9 сая төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын "Дотоод болон гадаад орнуудад зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэн яармаг, бизнес форумд орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжин оролцуулах зардал"-аас гаргаж үр дүн, ач холбогдол багатай БНХАУ-ын Бээжин, Шиамин хотод тоног төхөөрөмжийн үзэсгэлэн худалдаа үзэх, туршлага судлуулахаар 7 хүнийг 3 хоногийн гадаад томилолт олгож явуулсан байна. Мөн аймгийн Засаг даргын 2017.11.01-ний өдрийн А/638 тоот захирамжаар "Маск Арт" ХХК-д 1.2 сая төгрөгийг "Орхон хууль эрх зүйн хэлтэс" нэртэй public тохиргоотой, фэйсбүүк пэйж хуудас нээж ажиллуулахад олгосон, хамтран ажиллах гэрээний дагуу "Эр Жи Ор" ХХК-д Erdenetmedeel.mn сайтын мэдээний үйлчилгээний хөлс 1.5 сая төгрөг олгосон боловч тус сайт нь google.mn-ээс хайлт хийхэд олдохгүй байна.

Аймгийн Засаг даргын 2017.12.25-ны өдрийн А/794 тоот захирамжаар 200.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад, төсөл хөтөлбөрийн зардлын данснаас Эрдэнэт санд төвлөрүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө Сангийн сайдын 2012.11.15 -ны өдрийн 239 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3-д "Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх" гэсэн заалтын хүрээнд аймгийн Засаг даргын бүх захирамж гарч зарцуулагдсан байна. Тус хөрөнгийг зарцуулахдаа засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцээгүй, зөвхөн Засаг даргын захирамжаар зарцуулж байна. Тухайлбал: Хүндэтгэл үзүүлэх, гарын бэлэг, дурсгалын зүйл гардуулах, зочин төлөөлөгч хүлээн авах, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэх, гадаад оронд айлчлах, олон улсын форумд оролцох, хөрөнгө худалдан авах, Засаг даргын орон тооны бус зөвлөхөд сар бүр урамшуулал олгох зэрэгт зарцуулсан байна. Үүнээс Цагдаагийн газрын дугуйт эргүүлд зориулж 8.0 сая төгрөгөөр худалдан авсан унадаг дугуйг хаана ч бүртгэлд авалгүй орхигдуулсан байна. Энэ нь дээрх журмын 2.3-д "Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана", 3.1-д "Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна", 4.2-д "Тухайн шатны Засаг даргын Тамгын газар төсвийн зардлын тооцоог Санхүү, төсвийн асуудал хариуцсан хэлтэс /тасаг/-ээр хянуулан холбогдох газар, хэлтсээс санал авч, Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын захирамж гаргуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй.

**Шийдвэрлэсэн:** Дээрх зөрчлүүдээс 6.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, Эрдэнэт санд төвлөрүүлсэн 200.0 сая төгрөгийг ОНХО-ын дансанд төвлөрүүлэх, ТББ-тай байгуулах гэрээний урьдчилгаа төлбөрийг 50 хувиас хэтрүүлэхгүй байх, ЗДНХ-ийн 30-с доошгүй хувийг холбогдох журмын заалтын дагуу гэнэтийн нөхцөл байдлын хохирлыг барагдуулах зориулалтаар бэлэн байлгах, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх талаарх зөвлөмжийг удирдлагад өгснийг хүлээн зөвшөөрсөн болно.

## **10.2 Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дараах сангууд нэгтгэгдсэн. Үүнд:**

- Аймаг хөгжүүлэх Эрдэнэт сан
- Авто замын сан
- Баян-Өндөр, Жаргалант сумын сум хөгжүүлэх сан
- Нийгмийн халамжийн сан
- ОНХСан-3
- Төрийн албан хаагчийн орон сууцны сан –татан буугдсан.

Эрдэнэт сангийн санхүүгийн байдлын тайланд 2011 оноос 2015 он хүртэлх он тус бүрийн шилжих үлдэгдэл нэртэй УОО бүртгэлтэй байна. Тус урьдчилж олсон орлогууд нь хэзээ хэрэгжих нь тодорхойгүй, олон жил он дамжсан, урт хугацаат өр төлбөр байдлаар бүртгэлтэй байна. Үүнээс 2010-2011 оны 271.8 сая төгрөгийн жагсаалт байхгүй, 2014-2015

оны шилжих үлдэгдлээс 100.0 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч шилжүүлж бүртгэж 2014-2015 оны шилжих үлдэгдлийн УОО-г бууруулсан боловч тус оны жагсаалтад байхгүй, яаж хасагдсан нь тодорхойгүй эцсийн үлдэгдлийг тааруулж илэрхийлсэн байна. Аудитаар НББ-ийг зохих ёсоор хөтлөх, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон программ хангамжтай болох, он дамжсан авлага, УОО-г хэрхэн яаж үүссэнийг тодорхой болгож, жагсаалтыг тулган баталгаажуулж, барагдуулах арга хэмжээ авах талаар зөвлөмж өгсөн байна. Эдгээр нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байх тул санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн байна.

Авто замын сангийн аудитаар төсвийн данс хооронд шилжүүлэх авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, “Төсөл, тусгай сангуудын санхүүгийн тайлан бэлтгэх заавар”-ын 3.2-д болон 8.4-д заасныг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгсөн байна.

Баян-Өндөр болон Жаргалант сумын сум хөгжүүлэх сангаас 2011-2014 онд олгосон, зээлийн гэрээний хугацаа дуусч, гэрээний үүргээ биелүүлээгүй 179.2 сая төгрөгийн зээлийг төлүүлэх талаар албан шаардлага өгсөн байна.

Баян-Өндөр болон Жаргалант сумын ОНХС-д аудитаар 0.75 сая төгрөгийн албан шаардлага, 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 7.0 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна.

Халамжийн сангийн аудитаар 723.9 сая төгрөгийн залруулга хийгдэж, 389.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн байна. Орхон аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ирүүлсэн жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөг, авлагын тодруулгагүй, санхүүгийн тайлангийн тэмдэглэлийг бүрэн хэмжээнд бэлтгэн ирүүлээгүй, 2017 оны 12-р сард нийгмийн халамжийн сангийн төсвийг тодотгуулахдаа бодитой төлөвлөж, батлуулаагүйгээс 389.4 сая төгрөгийн өр үүсгэсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байх тул хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна.

### **10.3 Орон нутгийн хөрөнгө оруулалт**


Аймгийн ИТХ-н 2017 оны 12-р сарын 01-ны өдрийн ээлжит 9-р хурлын 9/02 дүгээр тогтоолын дугаар хавсралтуудаар хөрөнгө оруулалтын тодотгосон төсвийг баталсан байна. 2017 онд хөрөнгө оруулалтын 120 ажилд 8,973.8 сая төгрөг, шилжих хөрөнгө оруулалтын 113 ажилд 5,926.9 сая төгрөг, авто замын сангаас санхүүжих хөрөнгө оруулалтын 7 ажилд 607.6 сая төгрөг, ОНХСангаас санхүүжигдэх 16 ажилд 2,151.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тус тус тодотгон баталсан байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 2,308.0 сая төгрөгийг Орхон аймгийн ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлж, Авто замын сангын хөрөнгө оруулалтаар хийгдсэн долоон ажилд 552 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. 2018 оны 2-р сарын 23-ны өдрийн аймгийн ИТХ-н ээлжит 10-р хуралдаанаар орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээс үлдсэн ажил болон ОНХО-ын дансанд төвлөрүүлсэн 2,308.0 сая төгрөг мөн данс бүрийн үлдэгдэл санхүүжилтийг шилжих үлдэгдэл болгон батлуулсан байна.

### **Арван нэг. Нэмэлт санхүүжилтийн тайлан**

Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар тус дансанд 2017 онд 1,938.1 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, зарцуулсан ба зарцуулаагүй үлдэгдэл 154.3 сая төгрөгийн үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Орлого, зардлыг хүснэгтээр харуулбал:

(сая.төгрөгөөр)



- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаас орсон 45.01 сая төгрөг нь боловсролын салбарын байгууллагуудын эцэг эхийн хандивын орлого байна.

- ЗГНХ, ЗДНХ, ангилагдаагүй бусад зардлын орлого 1,122.61 сая төгрөгийн 218.7 сая төгрөг нь боловсролын байгууллагын, 850.9 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагуудын, 529.9 сая төгрөг нь бусад байгууллагуудын орлого байна.

- Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан орлогын 325.4 сая төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагын орлого, 112.7 сая төгрөг нь боловсролын салбарын байгууллагуудын орлого, 110.3 сая төгрөг нь ГБХЗХГ-ын Залуучууд хөгжлийн хөтөлбөр, хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт, 3.8 сая төгрөг нь бусад байгууллагын орлого байна.

- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор нийт 131.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд үүний 73.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллага, 26.1 сая төгрөгийг боловсролын салбарын байгууллагууд 29.3 сая төгрөгийг ГХБХБГазар, 2.9 сая төгрөгийн орлогыг бусад байгууллагууд бүрдүүлсэн байна.

- Урьд оны үлдэгдлээс санхүүжих орлого буюу 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар төсвийн байгууллагуудтай нэмэлт санхүүжилтийн хоорондын тооцоо нийлж 86.82 сая төгрөгийг буцаан олгохоор орон нутгийн нэгдсэн тайланд өглөг үүсгэж 2017 онд буцаан олгосон байна.

### Арван хоёр. Орон нутгийн өмчит ААН-ийн бүртгэл

Орхон аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд:

- “Эрдэнэт Ус ДТС” ОНӨХК
- “Гэр бүлийн ордон” ОНӨААТҮГ
- “ХББЗА” ОНӨААТҮГ
- “Их шүтээн цогцолбор” ОНӨААТҮГ
- “Эрдэнэт ШУТПарк” ОНӨААТҮГ
- “Хөх монгол цогцолбор” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар “Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ-т “Санал дүгнэлт өгөхөөс татгалзах” санал дүгнэлт өгсөн бол бусад 5 орон нутгийн өмчит аж ахуй нэгж “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

“Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” ОНӨААТҮГ нь нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтөлдөггүй буюу ерөнхий журнал, ерөнхий дэвтэр, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, нягтлан бодогч нь тайлант онд 2 удаа солигдсон, нягтлан бодох бүртгэлийн мэдлэг чадвар дутмаг, мэргэжлийн бус хүн тул ажил гүйлгээг алдаатай боловсруулах эрсдэл өндөртэй, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн

тайлангаа 2018.02.07-ны өдрийн 80 тоот албан бичгээр ирүүлсэн боловч тус тайлан нь хөрөнгө, эх үүсвэрийн дүн нь тэнцээгүй илтэд алдаатай илэрхийлэгдсэн тайлан байсан тул засварлаж ирүүлэхийг удаа дараа шаардаж 2018.03.10-ны өдрийн 138 тоот албан бичгээр 2018.03.12-нд дахин ирүүлсэн ба мөнгөн хөрөнгийн зөрүүтэй үлдэгдлээс авахуулаад НББ-ийн буруу бичилт, санхүүгийн программын алдаатай хэрэглээ, түүнээс үүдэлтэй буруу тайлагналыг залруулж, ажил гүйлгээг шинээр дахин боловсруулж санхүүгийн тайлан гаргаж ирүүлэхээр бүх баримт материалаа авч явсан боловч санхүүгийн тайлангаа залруулж гаргаж ирүүлээгүй аудиторыг цаг хугацааны хязгаарлалтад оруулж, аудит хийх боломжгүй болгосон болно. ТЕЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тус газрын тайлант оны нийт орлого 231.1 сая төгрөгөөр алдаа зөрчилд тооцсон болно.

Бусад ОНӨААН-үүдийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 450.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 262.8 сая төгрөгийн залруулга хийж, 1.4 сая төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг дахин давтахгүй байх 185.9 сая төгрөгийн 3 албан шаардлага, 13 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

## 2.8 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮН

### ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгддэг байгууллагуудад хийсэн аудитын дүн:

Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний аудитад хамрагдвал зохих нийт 94 байгууллагаас (ТЕЗ ороод ) 74.5 хувь буюу 70 нь аудитад хамрагдаж, аудитын түүвэрт 18.1 хувь нь буюу 17 байгууллагыг хамруулж, 7.4 хувьд буюу 7 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Үзүүлэлт	Байгууллагын тоо	Дүнд эзлэх хувь
Аудитад хамрагдаж дүгнэлт гаргуулсан	70	74.5
Түүвэрт хамруулсан	17	18.1
Итгэл үзүүлсэн	7	7.4
<b>Нийт хамрагдвал зохих байгууллага</b>	<b>94</b>	<b>100.0</b>

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар “зөрчилгүй санал дүгнэлт” – 62 байгууллагад, “хязгаарлалттай санал дүгнэлт”-7 байгууллагад өгч, 1 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Аудитаар хязгаарлалттай болон санал дүгнэлт өгөхөөс татгалзсан шалтгааныг харуулбал:

№	Байгууллагын нэр	Санал дүгнэлт	Хязгаарлалттай болон татгалзсан санал дүгнэлт авсан шалтгаан
1	Баян-Өндөр сумын ИТХ	хязгаарлалттай	Тайлант онд харилцах дансаар 4182,5 мянган төгрөгийн түлш шатахууны зардлыг Петровис ХХК-аас худалдан авч захиран зарцуулахдаа шаардах хуудсаар олгож, бараа материалын тайланд бүртгээгүй, жолоочийн тооцооны хуудас бүрэн бичигдээгүй, тооцоо бодсон ажилтан болон тооцоо бодуулсан жолоочийн гарын үсгээр баталгаажуулаагүй нь бүртгэлээр тавих хяналтыг алдагдуулсан байна.Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.
2	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	хязгаарлалттай	Тайлант 2017 оны эхний хагас жилийн үндсэн хөрөнгө болон бараа, материалын тооллогоор 10349.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 2275.0 мянган төгрөгийн бараа материал нийт 12624,6 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан. Уг асуудлыг шийдвэрлүүлэхээр аймгийн Цагдаагийн газарт хандсан тул хуулийн байгууллагын шийдвэр гартал эдгээр дутагдсан хөрөнгүүд тайлант оны жилийн эцэст бодитоор оршин байхгүй ч данснаас хасагдаагүй эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн бүртгэлд үлдэгдлээр тайлагнагдсан. Иймд дээрх алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон



			байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлаж байна.
3	Эрдэнэт сан	хязгаарлалттай	<p>Эрдэнэт сангийн санхүүгийн байдлын тайланд 2011 оноос 2015 он хүртэлх он тус бүрийн шилжих үлдэгдэл нэртэй урьдчилж орсон орлого бүртгэлтэй байна. Тус урьдчилж олсон орлогууд нь хэзээ хэрэгжих нь тодорхойгүй, олон жил он дамжсан, урт хугацаат өр төлбөр байдлаар оршин байна. Үүнээс 2010-2011 оны 271,805.0 мянган төгрөгийн жагсаалт байхгүй, 2014-2015 оны шилжих үлдэгдлээс 100,000.0 мянган төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч шилжүүлж бүртгэж 2014-2015 оны шилжих үлдэгдлийн урьдчилж олсон орлогыг бууруулсан боловч тус оны жагсаалтад байхгүй, яаж хасагдсан нь тодорхойгүй эцсийн үлдэгдлийг тааруулж илэрхийлсэн,</p> <p>Нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтөлдөггүй буюу ерөнхий журнал, ерөнхий дэвтэр, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, харилцахын гүйлгээг "эксэл" дээр боловсруулж, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг өөрийн дураар нэрлэж, бөглөж тайлан гаргадаг зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p>
4	Хот тохижуулах газар	хязгаарлалттай	<p>Нярав шатахууны орлогыг бүртгэхдээ анхан шатны баримтыг үндэслэж бүртгээгүй орлогыг 4.2 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн байхад тооцооны нягтлан бодогч хяналт хэрэгжүүлээгүй зарцуулалтыг илүү дүнгээр зарлагыг илэрхийлсэн. Мөн ерөнхий нягтлан бодогч нярав болон тооцооны нягтлан бодогчийн гаргасан орлого зарлагыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг хянаагүй, жилийн эцэст НИК ХХК-тай тооцоо нийлээгүйгээс 1.6 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд 2.5 сая төгрөгийн өглөг үүсгэсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүй байна. 38.7 сая төгрөгийн давс, 22,7 сая төгрөгийн цас хайлуулагч бодис, 30.3 сая төгрөгийн нормын хувцас шууд худалдан авалт хийсэн, 587,2 сая төгрөгийн шатахууныг нээлттэй тендер шалгаруулалтаар зарлалгүй НИК ХХК-тай шууд гэрээ байгуулж шатах тослох материалын худалдан авалт хийсэн байна. Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэсээс тогтоосон 245.6 мянган төгрөгийн төлбөрийн актын алданги болох 81.9 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардлын тэтгэврийн даатгалын зардлаас төлсөн байна. Төрийн аудитын газраас албан томилолтын зардалд тогтоосон 360,0 мянган төгрөгийн төлбөрийн актыг 11 ажилчидын цалингаас тус бүр 30,0 мянган төгрөгийг суутгаж авсан ч 1 ажилтаны 30,0 мянган төгрөгийг төсөөс төлсөн байна. Дарга цалингийн 25 хувийн нэмэгдэлийг 4 сар өөртөө тушаал гаргаж 950,0 мянган төгрөгийн нэмэгдэл авсан байна. Засгийн газрын 1995 оны 218-р тогтоолын 9-р зүйл, Сангийн сайдын 2011 оны 132-р тушаалын 2-р зүйл заалтыг зөрчиж албан томилолтын зардлыг 66,0 мянган төгрөгөөр илүү олгосон байна. Хүнд өгөх өглөг 3.7 сая төгрөг байхад 0.0 төгрөгийн өглөгтэй гэж тайлагнасан. Байгууллагад өгөх өглөг 21.1 сая төгрөг байхад 25.4 сая төгрөгөөр тайлагнасан. Шатахууны зардалд 1.6 сая төгрөгийн авлагатай байхад 2.5 сая төгрөгийн өглөгтэй гэж тайлагнасан. Санхүүгийн жилийн эцэст авлага өглөгийг хувь хүн болон харьцдаг аж ахуй нэгжтэй тооцоо нийлээгүй байна. Мөн ГХБХБГ-н 4.1 сая төгрөгийн өглөг, ЭМНДХ-н 0.002 сая төгрөгийн авлагыг бүртгээгүй байна. Кассын дансаар 10,8 сая төгрөгийг шагнал урамшуулал болон уралдаан тэмцээн зохион байгуулахад зарцуулсан байна. Анхан шатны баримтыг үзэхэд 10,3 сая төгрөгийн шагнал урамшуулал нь ажилчидын гарын үсэггүй олгосон зэрэг алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.</p>
5	Баян-Өндөр сумын ЗДТГ	хязгаарлалттай	<p>Тайлант онд ач санах дэд хөтөлбөрийн хүрээнд санхүүжилтээр авсан нийт 8,736.0 мянган төгрөгөөр багууд бэлэг дурсгал, хоол, архи, ундаа худалдан авч өгсөн, Засаг даргын нөөц сангийн хөрөнгөнөөс 11,797.0 мянган төгрөгийн үрэлгэн, зориулалт бус зардлуудыг гаргасан, шүүхийн шийдвэрээр ажилдаа буцаж орсон албан хаагчид цалингийн зардлаас 1,822.8 мянган төгрөг олгосон, 15 албан хаагчийг томилох, нэмэгдэл, нэмэгдэл хөлс нөхөн олговор олгох шийдвэр гаргахдаа Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолыг зөрчсөн, бараа материалын тайланд 680.7 мянган төгрөгийн аж ахуйн материалыг бичиг хэргийн материалын дансанд бүртгэж, шаардахаар зарлагдсан, тайлант онд худалдан авсан нийт 2,873.3 мянган төгрөгийн өртөгтэй ажлын хувцас, сагсан бөмбөг, нууцын тэмдэг, сагсны өмсгөлийг шаардах хуудсаар шууд зарлагдсан, бараа материалын дансанд тайлант онд</p>

			шинээр худалдан авсан 2,500.0 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийн шинжтэй зургийн аппарат,видео гэрлийг бүртгэж тайлагнасан, цалингийн зарлаас хэмнэгдсэн 34,895.9 мянган төгрөгийг 2017 оны 12 сард хоолны мөнгө хэлбэрээр олгосон, жижүүрийн цагийн бүртгэлээр ажлаа тасалсан 2 албан хаагчид цалинг бүтэн олгосон, тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр эд хогшил, урсгал засварын зардлаас зарцуулагдах ёстой усны тоолуурын 2,620.0 мянган төгрөгийг түлш, халаалтын зардлаас, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас зарцуулагдах ёстой СӨХ-ийн төлбөр 646.8 мянган төгрөгийг байрны түрээсийн зардлын ангилалаас тус тус гүйлгэн зарцуулсан, эрх барих эсхүл харъяа дээд байгууллагын зөвшөөрөлгүй бичиг хэргийн зардлаас 1,683.2 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг бэлтгэсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
6	Жаргалант сумын ЗДТГ	хязгаарлалттай	Тайлант онд 818.8 мянган төгрөгийн авлага, 117,608.8 мянган төгрөгийн өр үүссэн, ач санах дэд хөтөлбөрийн хүрээнд санхүүжилтээр авсан нийт 1,248.0 мянган төгрөгийг кассаар дамжуулан хүнсний бүтээгдэхүүн худалдан авч, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр дүнгүй зарцуулсан, Засаг даргын нөөц сангийн хөрөнгөнөөс 4,840.0 мянган төгрөгийн үрэлгэн, зориулалт бус зардлуудыг гаргасан, сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмаар зөвшөөрөгдсөн зардлаас бусад зардалд 15,282.1 мянган төгрөгийг кассаас зарцуулсан, шүүхийн шийдвэрээр буцаж орсон албан хаагчид цалингийн зардлаас 608.9 мянган төгрөг олгосон, 9 албан хаагчийг томилох, нэмэгдэл, нэмэгдэл хөлс нөхөн олговор олгох шийдвэр гаргахдаа Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолыг зөрчсөн, цалингийн зардлаас хэмнэгдсэн 17145.8 мянган төгрөгийг үр дүнгийн урамшуулал болон илүү цагийн хэмнэлтээр олгосон, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардлаас 75.0 мянган төгрөгийн өртөгтэй тоолуур, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 247.5 мянган төгрөгийн өртөгтэй цэвэрлэгээний материал тус тус худалдан авсан, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааны шийдвэрийг зөрчин сахилгын шийтгэл хүлээсэн 15 албан хаагчид 3042.0 мянган төгрөгийг олгосон, Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны 08 сарын 08-ны өдрийн А/37 тоот тушаалаар Жаргалант сумын иргэнд 1500.0 мянган төгрөгөөр гэр худалдан авч өгсөн, төсвийн хөрөнгөөр 19.5 мянган төгрөгөөр архи худалдан авч, зарцуулсан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
7	Халамжийн сан /Орон нутаг/	хязгаарлалттай	Орхон аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ирүүлсэн жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөг, авлагын тодруулгагүй, санхүүгийн тайлангийн тэмдэглэлийг бүрэн хэмжээнд бэлтгэн ирүүлээгүй, 2017 оны 12-р сард нийгмийн халамжийн сангийн төсвийг тодотгуулахдаа бодитой төлөвлөж, батлуулаагүйгээс 389,411.6 мянган төгрөгийн өр үүсгэсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
8	"ХББЗА" ОНӨААТҮГ	санал дүгнэлт дүгнэлт өгөхөөс татгалзсан	Нягтлан бодох бүртгэлийг зохих ёсоор хөтөлдөггүй буюу ерөнхий журнал, ерөнхий дэвтэр, бараа материал, үндсэн хөрөнгө, авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, нягтлан бодогч нь тайлант онд 2 удаа солигдсон, нягтлан бодох бүртгэлийн мэдлэг чадвар дутмаг, мэргэжлийн бус хүн тул ажил гүйлгээг алдаатай боловсруулах эрсдэл өндөртэй байна. "Хот байгуулалт, барилга захиалагчийн алба" ОНӨААТҮГ нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2018.02.07-ны өдрийн 80 тоот албан бичгээр ирүүлсэн боловч тус тайлан нь хөрөнгө, эх үүсвэрийн дүн нь тэнцээгүй илтэд алдаатай илэрхийлэгдсэн тайлан байсан тул засварлаж ирүүлэхийг удаа дараа шаардаж 2018.03.10-ны өдрийн 138 тоот албан бичгээр 2018.03.12-нд дахин ирүүлсэн ба түүнд дараах алдаа зөрчил оршин байна. Мөнгөн хөрөнгийн зөрүүтэй үлдэгдлээс авахуулаад НББ-ийн буруу бичилт, санхүүгийн программын алдаатай хэрэглээ, түүнээс үүдэлтэй буруу тайлагналыг залруулж, ажил гүйлгээг шинээр дахин боловсруулж санхүүгийн тайлан гаргаж ирүүлэхээр бүх баримт материалаа авч явсан боловч санхүүгийн тайлангаа залруулж гаргаж ирүүлээгүй аудиторыг цаг хугацааны хязгаарлалтад оруулж, аудит хийх боломжгүй болгосон болно. Үүнд:

		<p>1. Харилцах дансны эцсийн үлдэгдэл банкны хуулгаас зөрүүтэй, кассын тайланг сар бүр хүлээн авч хянадаггүй, ажил гүйлгээний баримтыг дараа нь нөхөж бүрдүүлдэг.</p> <p>2. Бараа материалын үлдэгдэл нотлогдохгүй, материалын орлого, зарлагын бүртгэл хөтөлдөггүй учраас нярвын гаргаж буй тайлангаас хамааралгүй, тодруулга дахь бараа материал зөвхөн барааны өсөлтөөр илэрхийлэгдсэн. Үүнээс гадна шатахууны зардалд анхан шатны баримт хөтөлдөггүй, бараа материалыг шууд зардалд бүртгэдэг.</p> <p>3. Эд хөрөнгийн тооллого зохион байгуулах тушаал гаргаж тооллого зохион байгуулаагүй, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтөлдөггүй тул үлдэгдэл нотлогдохгүй, бүртгэлээрх дүн, сангийн яамны э-тайлан болон орон нутгийн өмчийн хөрөнгийн бүртгэлийн программ дахь дүнгүүд хоорондоо бүгд зөрүүтэй тайлагнагдсан.</p> <p>4. Өглөгийн дүнгүүд нотлогдохгүй. Тухайлбал: тайлант онд үүсгэсэн цалингийн өглөг нь хэн хэнд, хэдэн төгрөг өгөх нь тодорхойгүй, татварын өр төлбөрүүд нь холбогдох татварын тайлангаарх өглөгийн дүнгээс зөрүүтэй, хяналтаар, хүү, торгууль, алдангаар нэмэлт өр төлбөр үүссэн боловч тайлагнаагүй, татварын тайланг алдаатай гаргаж хүргүүлдэг, мөн ажилчдыг бөөнөөр нь үндэслэлгүй халснаас шүүхийн шийдвэрээр эргэж томилогдоод одоо ажиллаж байгаа ажилчдын ажилгүй байсан хугацааны цалингийн өр төлбөрийг тодруулж тайлагнаагүй, хувь хүнд олгосон орлогоос татварын суутгал хийгээгүй олгосон.</p> <p>5. Цалин хөлс бодож олгохдоо НДШ, ХХОАТ-ын суутгалыг сар бүр янз бүр илүү, дутуу зөрүүтэй тооцоолдог.</p> <p>6. Хүүгийн орлогыг дутуу бүртгэснээс гадна хүүгийн орлогод болон 1,891.7 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны листны мөнгөнд НӨАТ ногдуулж бүртгэсэн, бусад орлого 190.7 мянган төгрөг юуны, ямар орлого болох нь тодорхойгүй, ажилтны цалингаас актын төлбөр суутгаж шилжүүлсэн 1,200.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны бус зардалд нэмж тайлагнаж өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан үр дүнгийн НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга хэсэгт мөн илэрхийлсэн.</p> <p>7. Аккруэл сууриар НББ хөтөлдөггүй буюу борлуулалтыг орлогыг зөвхөн мөнгөөр хэрэгжсэн үед нь хүлээн зөвшөөрч бүртгэж байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”-тэй нийцэхгүй.</p> <p>8. Үндэслэлгүй халагдаад шүүхийн шийдвэрээр эргэж томилогдоод буцаад чөлөөлөгдсөн албан хаагчдад ажилгүй байсан хугацааны цалингаас гадна ямар ч шийдвэр гаргалгүйгээр 2 сарын цалинтай тэнцэх нөхөн олговор олгосон, 2017 оны 02-р сард томилогдоод 8-р сард жирэмсэн, амаржсаны амралт авсан нягтлан бодогч өөртөө үндэслэлгүйгээр, мөн шийдвэргүйгээр 800,0 мянган төгрөгийн нөхөн олговор бодож авсан, одоо хяналтын инженерийн албан тушаалд байгаа боловч өмнө нь захирал болон ерөнхий инженер хийж байсан хүмүүсийн цалин хөлсийг захирал, ерөнхий инженерийн цалингаар цалинжуулж байна.</p>
--	--	---

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,616.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 2,501.7 сая төгрөгийн алдааг залруулж, 1,962.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 213 зөвлөмж, 16.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлж, 19.8 сая төгрөгийн 39 төлбөрийн акт тогтоож, 1,115.1 сая төгрөгийн 41 албан шаардлага тус тус хүргүүлсэн байна.

**Тусгай шилжүүлэг:** Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу ЭМС, ХАХНХС, БСШУС-ын багцын аймаг, нийслэл, сум дүүрэгт байршилтай харьяа байгууллагуудын 2017 оны тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв 33,489.3 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 33,489.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Гүйцэтгэлээр 33,370.4 сая төгрөгийг зарцуулж, 118.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тусгай шилжүүлгийн 64 байгууллагад хийсэн санхүүгийн аудитаар 1,684.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитын явцад 903.2 сая төгрөгийн залруулга хийн, 9.0 сая төгрөгийн 23 төлбөрийн акт тогтоож, 12.6 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 албан тушаалтанд хариуцлага тооцох санал хүргүүлж, 122.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг

давтан гаргахгүй байх 31 албан шаардлага, 637.5 сая төгрөгийн 136 зөвлөмж хүргүүлсэн байна.

## 2.9 ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг Орхон аймгийн СТСХ - ийн даргын 2017.06.21-ны өдрийн 6/1720 тоот болон 2017.09.18-ны өдрийн 6/2428 тоот албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажилласан байна. Орхон аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн нийт 10 зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай байна.

№	Зөвлөмжийн утга	Хэрэгжилтийн хувь
1	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллах, хэлтэс албадын ажлын уялдааг сайжруулж, үр дүнг тооцох	100
2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилган, аудитын зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллаж, дотоод хяналтыг сайжруулах.	80
3	Төсвийн шууд захирагч нарын урсгал зардалд батлагдсан хөрөнгийн худалдан авалтад хяналт хэрэгжүүлж, Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнгийн гэрээг үнэн зөв, бодитой дүгнэх.	80
4	Орон нутгийн өмчит ААН-үүд алдагдалтай ажиллаж байгаад хяналт хэрэгжүүлж, чиг үүргийн дагуу ажиллуулж, үр ашигтай ажиллах боломж бүрдүүлэх	60
5	Захирамжийг холбогдох албан хэрэг хөтлөлтийн зааварт нийцүүлэх	90
6	Өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангуулж, 2017 оны 07 сарын 01-ний өдрийн дотор хариуг ирүүлэх.	80
7	Төсвийн байгууллагуудын төсвийн төсөлд өгсөн саналыг тооцоо судалгаанд үндэслэн хянаж, бодитой төлөвлөх.	80
8	Төсвийн байгууллагуудын ур чадвар, үр дүнгийн урамшуулал олголтын тооцооллыг хянаж, төсвийн захирагч нарын төсвийн сахилга батыг сайжруулах.	80
9	Анхан шатны баримтын бүрдлийг хангуулаагүй баримтаар ажил гүйлгээг хийхийг таслан зогсоон, баримтын бүрдлийг хангуулаагүй гүйлгээ хийлгэсэн албан тушаалтан, ТББ-д санхүүжилт олгохгүй байж, төрийн сангийн гүйлгээний ажилтнуудын хариуцлагыг сайжруулах.	80
10	Шинээр ажилд авч буй нягтлан бодогч нарт тавих шаардлагыг нэмэгдүүлж, ур чадварыг үнэлж, үнэлэлт өгч, хариуцлагыг сайжруулах.	80

## 2.10 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Орхон аймгийн ТЕЗ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Орхон аймгийн ТЕЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

БЭЛТГЭСЭН:  
АУДИТОР:

**АУДИТЫН ТАЙЛАНГ**



Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

2018.04.20

### 3 Менежментийн захидал



**ОТАГ**  
ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## ОРХОН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Орхон аймаг дахь Төрийн  
аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор  
Ц.Нармандах  
Утас: 70353088  
Цахим хаяг:  
orkhon@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ  
Утас: 70355805  
Цахим хаяг:  
[orkhon@audit.gov.mn](mailto:orkhon@audit.gov.mn)

Аудитор: Г.Оргилмөрөн  
Утас: 70350757  
Цахим хаяг:  
orkhon@audit.gov.mn

**ТАБ-ын хаяг:** Орхон аймаг дахь  
Төрийн аудитын газар  
**Байршил:** Хүрэнбулаг баг  
Нутгийн удирдлагын ордон  
**Цахим хуудас:** [www.audit.mn](http://www.audit.mn)

Аудитын код: ОРА-2018/1/СТА-ТЕЗ

### Менежментийн захидал

Асуудал 1	
Орлогын талаар.....	31
Асуудал 2	
Мөнгөн хөрөнгийн талаар.....	31
Асуудал 3	
Зардлын талаар.....	32
Асуудал 3	
Авлага, өр төлбөрийн талаар.....	33

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь *Орхон аймгийн ТЕЗ-ийн* нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.**

### 3.1 Орлогын талаар

#### Илрүүлэлт

2017 онд бэлэн бус торгуулийн системээр давхардсан тоогоор 16014 иргэнд 1,076.2 сая төгрөгийн торгууль ноогдуулсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн орлогод 512.6 сая төгрөгийн орлого төвлөрч 563.5 сая төгрөгийн орлого ороогүй байна. Цагдаагийн газраас бэлэн бусаар тавьсан торгууль нь 15 хоногийн дотор төлөгдсөн байхаар тавигддаг байна. Цаашид уг орлогыг тухайн онд орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлж орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлж ажиллах бүрэн боломжтой байна.

#### Хариуцах ажилтан

Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут, СТСХ-ийн дарга Н.Бямбацэцэг

#### Эрсдэл

Эргэх холбоо бүхий хяналтын механизмгүйгээс зөрчил гаргагч торгуулийг тухай бүр төлөхгүй байх, давтан гаргах, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх боломжоо ашиглахгүй байх, төлөвлөсөн арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах.

#### Зөвлөмж

1. Бэлэн бус торгуулийн системээр тавигдсан торгуулийг тайлант онд багтаан төвлөрүүлэх хяналтын эргэх холбоог бий болгох, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, дутуу төлөгдсөн торгуулийн орлогыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах

#### Төсвийн захирагчийн хариу

ТЕЗ-ийн 2018.04.23-ны өдрийн 1/1273 тоот албан бичгээр хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахаа мэдэгдсэн.

### 3.2 Мөнгөн хөрөнгийн талаар

#### Илрүүлэлт

Төрийн сангийн арилжааны банкн дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хуучин төсвийн байгууллагуудын бэлэн мөнгөний гүйлгээг дамжуулж гаргадаг байсан гэх Төрийн банкн дахь сар бүр хүү тооцож олгодог 97.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй болон 9.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй данс багтаж байна. Уг данснаас урьдчилж мөнгө гаргаж авах зэргээр зориулалт бусаар ашиглаж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэсэн заалт болон Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтарсан 2013 оны 24/24/А-9 тоот хавсралтаар баталсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг монголбанк, банкинд нээх, хаах журам”-тай нийцэхгүй байна.

#### Хариуцах ажилтан

Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут, СТСХ-ийн дарга Н.Бямбацэцэг

#### Эрсдэл

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах, бэлэн мөнгө дутагдах, ашиглал үүсэх, хяналт алдагдах

#### Зөвлөмж

2. Төрийн сангийн Төрийн банканд байршиж буй дансны зориулалтыг тодорхой болгох, үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлэх, холбогдох хууль, журмын хүрээнд зориулалтын дагуу ашиглах.

#### Төсвийн захирагчийн хариу

ТЕЗ-ийн 2018.04.23-ны өдрийн 1/1273 тоот албан бичгээр хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахаа мэдэгдсэн.



### 3.3 Зардлын талаар

#### Илрүүлэлт

Аймгийн Засаг даргын 2017.12.25-ны өдрийн А/794 тоот захирамжаар 200.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын хуваарилагдаагүй бусад, төсөл хөтөлбөрийн зардлын данснаас Эрдэнэт санд төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Тайлан оны ТШЗ-чдын санхүүгийн тайлангийн аудитаар дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал болон цалингийн зардлын хооронд буюу зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулах явдал түгээмэл гарч байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-тай нийцэхгүй байна.

АИТХ-ын 2017.12.01-ний өдрийн 09/02 дугаар тогтоолоор аймгийн халамжийн сангийн төсвийг 605.0 сая төгрөгөөр бууруулж 7,842.8 сая төгрөгөөр баталжээ. Үүнтэй холбоотойгоор халамжийн зардлын эх үүсвэр 389.4 сая төгрөгөөр дутагджээ. Халамжийн сангийн 2016 оны зардал 8,056.7 сая төгрөг, 2017 оны зардал 8,091.1 сая төгрөг болсон байна.

#### Хариуцах ажилтан

Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут, СТСХ-ийн дарга Н.Бямбацэцэг

#### Эрсдэл

Холбогдох хууль, тогтоомж зөрчих, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах.

#### Зөвлөмж

3. Засаг даргын хуваарилагдаагүй бусад, төсөл хөтөлбөрийн данснаас Эрдэнэт санд төвлөрүүлсэн хөрөнгийг ОНЕО-ын дансанд буцаан төвлөрүүлэх.

4. Цалин хөлс болон ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал нь тусдаа бүлгийн дүнгээр хянагддаг зардал тул бүлэг хооронд санаатай, санамсаргүй гүйлгэн зарцуулахгүй байхыг ТШЗ, тэдгээрийн нягтлан бодогч нарт даалгаж, СТСХ-ээс Төсвийн байгууллагуудын цалин, НДШ-ийн гүйлгээг хүлээн авч шилжүүлэхдээ хяналт хэрэгжүүлэх.

